

**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ, УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ,
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба

Шийд- вэрийн д/д	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт				Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан										
1	2	3	4				5	6										
НЭГ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ																		
88	Засгийн газарт чиглэл өгөх тухай, 2013-06-10 №88	1.Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх “шилэн данс”-ны тогтолцоонд шилжих;	<p>2024 онд аймгийн Засаг даргын төсвийн багцад хамраарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд улирал бүр аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудитыг гүйцэтгэн байгууллага бүрд илэрсэн зөрчил, дүгнэлт, зөвлөмжийг тайлангаар хүргүүлэн ажиллалаа.</p> <table border="1"> <thead> <tr> <th align="center">Нэгдсэн дүн</th> <th align="center">2023 он 4 улирал</th> <th align="center">2024 он 1 улирал</th> <th align="center">2024 он 2 улирал</th> <th align="center">2024 он 3 улирал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td align="center">98%</td> <td align="center">98%</td> <td align="center">96.6%</td> <td align="center">97%</td> <td align="center">98%</td> </tr> </tbody> </table> <p>Дотоод аудитаар 79 байгууллага 81-100% хангалттай сайн, 5 байгууллага 80%-аас доош үнэлэгдсэн тул ажил сайжруулах албан бичгийг хүргүүлж, биелэлтийг албан бичгээр хүлээн авч ажилласан. Үүнд:</p>				Нэгдсэн дүн	2023 он 4 улирал	2024 он 1 улирал	2024 он 2 улирал	2024 он 3 улирал	98%	98%	96.6%	97%	98%	байхгүй	Байхгүй
Нэгдсэн дүн	2023 он 4 улирал	2024 он 1 улирал	2024 он 2 улирал	2024 он 3 улирал														
98%	98%	96.6%	97%	98%														

			№	Байгууллагын нэр	Үнэлгээ	Авсан арга хэмжээ			
			1	Хот тохижуулах газар	76%	Албан бичиг			
			2	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	78%				
			3	Уран эгшиг сургууль	80%				
			4	2-р сургууль	80%				
			5	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	80%				
			<p>2024 онд Аймгийн Засаг даргын 2023.11.02-ны өдрийн А/845 дугаар захирамжаар Худалдан авах ажиллагааны газар байгуулагдсан. Мөн Баян-Өндөр цэцэрлэг 2024.01.29-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлэн, Шилэн дансны нэгдсэн цахим системд 2024 оны 02 дугаар сард цэс үүссэн.</p> <p>2024 оны 3 дугаар улирлын байдлаар байгууллагуудын цаг хугацаандаа мэдээлэл байршуулсан байдал 99.4 хувь, иж бүрэн, үнэн зөв мэдээлсэн байдал 97.2 хувь, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн нэгдсэн дүн 98 хувьтай дүгнэгдлээ.</p> <p>2024 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, сургалт, үйл ажиллагааны тайланг улирал бүр дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт Эрсдэлийн удирдлагын газар, аймгийн ИТХ, Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэст дотоод аудитын нэгдсэн тайлан, - Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Соёл урлагийн газар зэрэг байгууллагуудад харьяалагдах байгууллагын дотоод аудитын тайлан, 						
		2.Төсвийн зарцуулалтад гүйцэтгэл, тавих					Байхгүй	Байхгүй	

		<p>иргэний хяналтын тогтолцоо хийгээд өнөөгийн эрх зүйн орчины талаар олон нийтэд сурталчилах, иргэдийн санал дүгнэлтийг хүлээн авсан эсэхийг эргэж мэдэгдэж байх тогтолцоог нэвтрүүлэх.</p>	<p>Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор албаны 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 4 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж давхардсан тоогоор 172 байгууллагын 288 мэдээлэл оруулагч нар болон албаны холбогдох албан хаагчид, мөн 88 иргэдийн төлөөлөлд сургалт, мэдээлэл өгч, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээлэл байршуулах эрх бүхий албан хаагчдад “2023 он, 2024 оны I улирлын дотоод аудитын нэгдсэн дүн, нийтлэг алдаа, зөрчил, цахим системд мэдээлэл байршуулахад анхаарах зарим асуудал” сэдвээр ээлжит сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтад 50 байгууллагын 50 мэдээлэл оруулагч хамрагдлаа. 2. Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл оруулагч нарын мэдээлэл байршуулалтыг сайжруулах арга зүй” сэдэвт сургалтыг 2024.10.04-ний өдөр шилэн дансны нэгдсэн цахим системд 2-оос дээш мэдээлэл оруулагчтай байгууллагуудын мэдээлэл оруулагч, нягтлан бодогч нарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 9 байгууллагын 29 албан хаагч хамрагдлаа. 3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн зөвлөмжийн хүрээнд “Шилэн дансны цахим системд хандалт хийх арга зүй” сэдэвт сургалтыг Орхон аймгийн Баян-өндөр сум, Жаргалант сумуудын 29 багийн ажлын алба, Иргэдийн нийтийн хурал, иргэдийн төлөөллийг хамруулан 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Баян-Өндөр сумын ажлын алба, иргэдийг “Залуучуудын ордон”-д, Жаргалант сумын ажлын алба болон иргэдийг “Жаргалант сумын ИНХ-ын танхим”-д зохион байгуулсан. сургалтад Орхон аймгийн 29 багийн ажлын албаны албан хаагч 125, Иргэдийн нийтийн хурал, иргэдийн төлөөлөл 88, нийт 213 хүн оролцсон. 		
--	--	--	---	--	--

			<p>4. Шилэн дансны нэгдсэн системд мэдээлэл байршуулах эрх бүхий албан хаагчдад 2024 оны II, III улирлын дотоод аудитын нэгдсэн дүн, нийтлэг алдаа, зөрчил, цахим системд мэдээлэл байршуулахад анхаарах зарим асуудал” сэдвээр ээлжит сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр танхимаар зохион байгууллаа. Сургалтад 71 байгууллагын 71 мэдээлэл оруулагч хамрагдсан.</p> <p>Мөн Оюу, 18 дугаар цэцэрлэг, Уран эгшиг, 16 дугаар сургууль, Жаргалант сумын Эрүүл мэндийн төв, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж, Хүүхэлдэйн театр, Соёл урлагийн газар, Нийтийн номын төв, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар зэрэг 10 байгууллагын нягтлан бодогчдод ажлын байранд ганцаарчилсан зөвлөгөө өгч, 45 байгууллагын нягтлан бодогчдод утсаар мэдээлэл өгч, арга зүйгээр хангаж ажилласан байна.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, сурталчлах зорилгоор дараах арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажилладаг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас-СХДАА”, “Орхон Төрийн сан” зэрэг цахим хуудсаар дамжуулан Шилэн дансны цахим системийн шинэчлэл, бүртгэл үүсгэх, мэдээлэл байршуулалттай холбоотой 11 удаагийн зөвлөгөө, мэдээллийг хүргүүлээ. Мөн албаны www.Sankhuu.audit.or.gov.mn сайтад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хийгдсэн дотоод аудитын мэдээллийг тогтмол байршуулж байна. 2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын дүн, холбогдох мэдээллийг “Тусгал” телевизэд 4 удаа ярилцлага өгч, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Номин телевизтэй хамтран зохион байгуулдаг “Хуулийн цаг” нэвтрүүлгээр 2 удаа мэдээ, мэдээлэл өгч иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллалаа. 		
--	--	--	--	--	--

Хэсгийн дундаж хувь				100%	
ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ					
15	Чиглэл өгөх тухай 2014 он Дугаар №15	<p>1.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хэрэгжих боломжгүй төсөл сонгон шалгаруулсан болон төслүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох</p>	<p>2024 онд Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан, Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан зэрэг орон нутгийн 2 тусгай сангийн 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <p>1. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан: Дотоод аудитаар илэрсэн 1 зөрчилд 3 зөвлөмж хүргүүлэн 2023 оны санхүү, үйл ажиллагааг САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ гэж дүгнэсэн байна.</p> <p>2. Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан: Дотоод аудитаар 2023 оны санхүү, үйл ажиллагааг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсэн байна.</p> <p>Дотоод аудитаар илэрсэн зөрчил, дотоод аудитын тайлан, дүгнэлтийг албаны дарга-Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчаар хянуулан баталгаажуулж, тус сангуудын удирдлага, холбогдох албан хаагчдад танилцуулан ажилласан байна.</p> <p>Дотоод аудитаар илэрсэн зөрчлийг залруулж ажилласан тухай биелэлтийн тайланг 2 сангаас албан бичгээр хүлээн авч, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.</p> <p>Сум хөгжүүлэх сангийн журам хүчингүй болсон.</p>	Байхгүй	Байхгүй
		<p>2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ</p>	<p>2024 онд Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан, Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан зэрэг орон нутгийн 2 тусгай сангийн 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <p>1. Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан: Дотоод аудитаар 5 зөрчил илэрч, 37,660.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчлийг залруулах албан</p>	Байхгүй	Байхгүй

		<p>гүйцэтгэхээр гэрээ байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдийн зөрчлийг хянан үзэж, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах</p>	<p>шаардлага, ажил сайжруулах 5 зөвлөмж хүргүүлэн 2023 оны санхүү үйл ажиллагааг САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ гэж дүгнэсэн байна.</p> <p>2. Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан: Дотоод аудитаар сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Болзошгүй аваарын зардал" гэж хуваарилан хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт болон орон нутгийн иргэдийн саналын эрэмбэд ороогүй дараах 12 ажлын гүйцэтгэлд нийт 209,009.4 мянган төгрөгөөр зарцуулсан, 2023 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд мэдээлбэл зохих мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, удирдамжгүйгээр хяналт шалгалтыг зохион байгуулсан зэрэг 3 зөрчил илэрсэн тул тус сангийн 2023 оны үйл ажиллагааг САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ гэж дүгнэн, 1 албан шаардлага, ажил сайжруулах 3 зөвлөмж хүргүүлсэн байна.</p> <p>Цаашид 2 сангийн үйл ажиллагааг аудитаар илэрсэн асуудалд анхаарч, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилтийг ханган ажиллах, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ажлуудыг санхүүжүүлэхгүй байх, хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд иж бүрэн байршуулах, иргэд, олон нийтийг бодит, үнэн зөв мэдээллээр хангах зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж болгон хүргүүлсэн.</p> <p>Дотоод аудитаар илэрсэн зөрчил, дотоод аудитын тайлан, дүгнэлтийг албаны дарга-Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчаар хянуулан баталгаажуулж, тус сангуудын удирдлага, холбогдох албан хаагчдад танилцуулан ажилласан байна.</p> <p>Дотоод аудитаар илэрсэн зөрчлийг залруулж ажилласан тухай биелэлтийн тайланг 2 сангаас албан бичгээр хүлээн авч, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.</p>		
--	--	--	---	--	--

27	“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 2024.04.18-ны өдрийн №27	2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	“Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн хамаарах зорилт, арга хэмжээг жил бүр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажилладаг. Мөн албан хаагч бүр “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээг тусган ажилладаг.	Байхгүй.	Байхгүй.
УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ					
2024-06	“Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай” 2024.11.06-ны өдрийн №2024-06 ЁЗДБХ,	1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 4 зорилтын хүрээнд хамаарах арга хэмжээг тодорхойлон жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хагас бүтэн жилээр биелэлтийг тайлагнан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилласан.	Байхгүй.	Байхгүй.

		<p>1.3 Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.</p>	<p>Албаны даргын 2024 оны А/14, А/30 дугаартай тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг албаны https://sankhuu.orkhon.gov.mn/ цахим сайт, албаны дундын групп-т тус тус байршуулж, албан хаагчдад танилцуулж ажилласан. ➢ Шинээр томилогдсон 4 албан хаагчид “Төрийн албаны ёс зүйн тухай хууль”, Ёс зүйн дүрэм, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн. ➢ 2024 онд Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан 5 удаагийн сургалтад албаны дарга, хорооны гишүүд хамрагдсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” сэдэвт сургалт - “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт”, “Төрийн албаны зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан”-ийн танилцуулга” сургалт - “Ажлын байрны ёс зүй, ажлын ёс зүй, хувь хүний ёс суртахуун болон ёс зүйн тухай хууль тогтоомж” сэдэвт сургалт - “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Захиргааны ерөнхий хуулийн агуулга, хэрэглээнд анхаарах асуудал”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хэрглээнд анхаарах асуудал” сэдэвт сургалт - Ёс зүйн академаас Эрдэнэт хотод зохион байгуулсан “Байгууллагын ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалт 	Байхгүй.	Байхгүй
--	--	--	--	----------	---------

			<p>➤ Албаны Ёс зүйн дэд хорооноос нийт албан хаагчдад 3 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Байгууллагын ёс зүй болон хувь хүний ёс зүй” - “Ажлын байрны ёс зүй” - “Өөртөө итгэх итгэл, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах” <p>2024 онд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гомдол ирээгүй болно.</p> <p>Төлөвлөгөөний биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр тогтоосон хугацаанд “Төрийн албаны Орхон аймаг дахь салбар зөвлөл”-д хүргүүлэн ажилласан.</p>		
Хэсгийн дундаж хувь				100%	
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ					
196	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 №196	3. "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем" -ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	<p>Хүний нөөцийн бодлогыг дэмжих "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийн талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийн талаарх сургалтад албаны дарга хамрагдаж мэдээлэл авсан. ➤ 2024.11.01-ний өдөр “Төрийн албаны зөвлөл”-өөс зохион байгуулсан хүний нөөцийн цахим системд “Албан тушаалын тодорхойлолт” шивж, хянуулах, батлуулах туршилтад албаны “Албан тушаалын тодорхойлт” боловсруулах ажлын хэсгийн 3 албан хаагч оролцсон. ➤ Тус системийг ашиглаж эхлэхтэй холбоотой албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдлыг шинэчлэн бүрдүүлж ажиллаж байна. 	Байхгүй	Байхгүй
163	“Төрийн байгууллагын үйл	2. Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах		Байхгүй	Байхгүй

	ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2024.11.13-ны өдрийн №163	баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	2024 онд албаны албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжуудад лиценз байхгүй. Лицензтэй программ ашиглахаар 2025 оны төсвийн төсөлд тусгуулахаар холбогдох материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.		
109	“Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 2024.10.02-ны өдрийн №109	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай	Албаны даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/33 дугаартай тушаалаар “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт оруулах ажлын хэсгийн томилсон. Ажлын хэсэг дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын Ёс зүйн дэд хороо нь 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа албан хаагчдынхаа өмнө танилцуулж, биелэлтээ дүгнүүлж ажиллалаа. Албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Б/34 дугаартай тушаалаар Ёс зүйн дэд хорооны дарга болон гишүүдэд 1,320.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг бодож олгосон.	Байхгүй	Байхгүй
Хэсгийн дундаж хувь				100%	
ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ					
64	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	14.5.2. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зайлшгүй тохиолдолд	Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 8 удаагийн шалгалтаар 19 байгууллагын 2022, 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа болон 2025 оны төсвийн төсөвд хяналт шалгалт хийлээ. Үүнд:	Байхгүй	Байхгүй

	2021.12.14 №64	<p>холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийх, хяналт шалгалтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгав.</p>	<p>1. Аймгийн ЗДТГ-н Хууль, эрх зүйн хэлтсээс манай албанд цохож ирүүлсэн иргэн Б.Нямжаргалын өргөдөл гомдлын дагуу аймгийн Засаг даргын орлогчийн баталсан 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05/24 тоот “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт” хийх удирдамжийн дагуу Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт</p> <p>2. Сангийн Сайдын баталсан 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн СХШХ/03 дугаар “ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА ГААЛИЙН ГАЗАР, ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГДСЭН УДИРДАМЖ”, аймгийн Засаг даргын орлогчийн баталсан 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 17/24 дугаар удирдамжийн дагуу “Орхон аймаг дахь Гаалийн газар”-ын 2022, 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт</p> <p>3. Соёлын яамны 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн №ХШҮДАГ-2024-ДА/14 дугаартай “Соёлын сайд буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж”, Соёлын сайдын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 10/1544 дугаартай албан бичиг, Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 40/24 дугаартай удирдамжийн хүрээнд аймгийн хэмжээний нийт 10 соёлын байгууллагын 2024 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт</p> <p>4. Хот тохижуулах газрын 2024 оны 1-8 дугаар сарын төсвийн гүйцэтгэл, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлагналд аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 41/24 дугаартай баталсан удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалт</p> <p>5. Сангийн яамны 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн № СХШХ/07 дугаартай “Татварын ерөнхий газар болон түүнийн харьяа газар, хэлтсийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж”-ын дагуу Орхон</p>		
--	-------------------	--	--	--	--

			<p>аймгийн Татварын хэлтэсийн 2022, 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт</p> <p>6. Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 52/24 дугаартай удирдамжаар “Хот тохижуулах газар”, “Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар” УТҮГ, “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа” УТҮГ-ын 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн төсөлд дотоод аудит</p> <p>7. Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 57/24 дугаартай удирдамжаар “Хот захирагчийн алба”-ны Болзошгүй аваарын зардлын 2024 оны төсвийн гүйцэтгэлд нийцлийн аудитыг тус тус гүйцэтгэлээ.</p> <p>8. Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 59/24 дугаартай удирдамжаар “Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар”-ын 2024 оны 01 дүгээр сарын 02-нд өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааны аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн ажлын 7 хоногт гүйцэтгэж дуусгана. Шалгалтын гүйцэтгэлийн явц 80%-тай байна.</p>		
		<p>14.5.3 Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн хяналт шалгалтыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 50 хувиар бууруулах чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг төлөвлөж,</p>	<p>Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөхдөө Төрийн аудитын байгууллагын төлөвлөгөөт шалгалттай давхардуулахгүй байхаар төлөвлөн ажилладаг.</p> <p>Орон нутгийн төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит хувьцаат компани болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх 2024 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан бөгөөд тус онд нийт 60 байгууллагад хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөн. Үүнд:</p> <p>1. Дотоод аудит: 2024 онд 32 байгууллагад дотоод аудитыг гүйцэтгэн засаглал, эрсдэл, дотоод хяналтын тогтолцоог үнэлж, эрсдэлд суурилсан аудитыг гүйцэтгэж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгч, албан шаардлага, зөвлөмж хүргүүлэн биелэлтийг тооцож</p>	Байхгүй	Байхгүй

		хэрэгжүүлэхийг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд зөвлөв.	<p>ажилласан. 32 удаагийн дотоод аудитаар эрсдэлийг үнэлэхэд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ БАГА эрсдэлтэй-19 байгууллага, ДУНД эрсдэлтэй 11 байгууллага, ИХ эрсдэлтэй 1 байгууллага дүгнэгдэж, 1 байгууллагын дотоод аудит 80% тай үргэлжилж байна. Удирдамжийн хугацаа дуусах болоогүй байна. <p>2. Санхүүгийн хяналт шалгалт: 2024 онд 28 байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд нотлох баримтад суурилан санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгч, нөхөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлэн биелэлтийг тооцож ажилласан. 28 байгууллагын эрсдэлийг үнэлэхэд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ БАГА эрсдэлтэй-11 байгууллага, ДУНД эрсдэлтэй-15 байгууллага, ИХ эрсдэлтэй үнэлэгдсэн байгууллага байхгүй байна. 2 байгууллагын санхүүгийн хяналт шалгалт 80%-тай үргэлжилж байна. Удирдамжийн хугацаа дуусаагүй байна. <p>Нийт 60 байгууллагаас 57 байгууллагын эрсдэлийн үнэлгээг нэгтгэн албаны “Эрсдэлийн мэдээллийн сан”-д оруулсан. 3 Байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт 80%-тай үргэлжилж байна.</p>		
31	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл	31.9.6. 2/ Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг,	Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст албаны мэдээлэл байршуулахтай холбоотой холбогдох материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Байхгүй	Байхгүй

		нийслэлийн Засаг дарга нарт			
Хэсгийн дундаж хувь				96.6%	
Нийт дундаж хувь				99 %	

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА